

ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХК
2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Хагас жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 2/

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй

Тайлагнах хугацаа	2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2024 оны 6 дугаар сарын 30-ны өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Компанийн нэр: Худалдаа, хөгжлийн банк ХК (цаашид "Банк" эсхүл "ХХБ" гэх) УБГД: 9007001015 Үнэт цаасны код: MN00TDB05673 Утасны дугаар: 11 328227
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Банк, санхүү
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	50,600,927
Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: Л.Сайнбаяр - Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх ажлын албаны Гадаад харилцааны мэргэжилтэн Хянасан: Н.Нямсүрэн - ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

1. Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/

	№	Үзүүлэлт	Мянган төгрөг/
			Эцсийн үлдэгдэл
Санхүүгийн байдлын үзүүлэлт	1	ХӨРӨНГӨ	0.0
	1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	3,456,325,024.1
	1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	1,569,769,294.3
	1.3	Хөрөнгө оруулалт	779,148,249.8
	1.4	Зээл (цэвэр дүнгээр)	5,586,904,295.6
	1.5	Дериватив санхүүгийн хөрөнгө	50,068,792.7
	1.6	Бусад санхүүгийн хөрөнгө	163,573,927.9
	1.7	Бусад санхүүгийн бус хөрөнгө	218,688,232.6
	1.8	Үндсэн хөрөнгө	569,736,899.7
	1.9	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	56,759,674.3
	1.10	Борлуулах зориулалттай хөрөнгө	136,772,380.8
	1.11	Биет бус хөрөнгө	38,289,151.7
	1.12	Нийт хөрөнгийн дүн	12,626,035,923.4
	2	ӨР ТӨЛБӨР	0.0
	2.1	Харилцах	3,718,189,143.7
	2.2	Хадгаламж	4,790,168,315.9
	2.3	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	2,207,732,902.1
	2.4	Бусад эх үүсвэр	212,164,499.6
	2.5	Дериватив санхүүгийн өр төлбөр	20,088,851.5
	2.6	Бусад санхүүгийн өр төлбөр	207,138,535.7
	2.7	Бусад санхүүгийн бус өр төлбөр	71,589,409.7
	2.8	Хоёрдогч өглөг	0.0
	2.9	Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр)	0.0
	2.10	Нийт өр төлбөрийн дүн	11,227,071,658.3
	3	ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	0.0
	3.1	Хувь нийлүүлсэн хөрөнгө	340,852,904.4
	3.2	Нэмж төлөгдсөн капитал	64,069,779.4
	3.3	Халаасны хувьцаа	0.0
	3.4	Дахин үнэлгээний нэмэгдэл	139,303,196.0
	3.5	Хуримтлагдсан ашиг, алдагдал	813,342,605.0
	3.6	Бусад өөрийн хөрөнгө	41,395,780.4
	3.7	Өөрийн хөрөнгийн дүн	1,398,964,265.1
	4	Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	12,626,035,923.4

		/Мянган төгрөг/	
№	Үзүүлэлт	Эцсийн үлдэгдэл	
1	Хүүгийн орлого	511,463,096.3	
2	Хүүгийн зардал	282,155,777.4	
3	ЦЭВЭР ХҮҮГИЙН ОРЛОГО(1-2)	229,307,318.9	
4	Эрсдэлийн сангийн зардал	17,254,328.9	
5	Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого [(3)-(4)]	212,052,990.1	
6	Бусад орлого	175,445,985.5	
7	Бусад зардал	199,264,079.0	
8	Татварын өмнөх ашиг, алдагдал (5+6-7)	188,234,896.5	
9	Орлогын татварын зардал	14,090,314.1	
10	Татварын дараах ашиг, алдагдал (8-9)	174,144,582.4	
11	Зогсоосон үйл ажиллагааны цэвэр орлого, зардал	0.0	
12	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал (10+11)	174,144,582.4	
13	Бусад дэлгэрэнгүй орлого	1,310,012.9	
14	Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлогын дүн (12+13)	175,454,595.4	
		/Мянган төгрөг/	
№	Тэнцлийн гадуурх данс		
1	Зээл, зээлтэй адилтгах хөрөнгөд хамаарах үүрэг (цэвэр дүнгээр)	1,268,030,702	
		/Мянган төгрөг/	
№	Үзүүлэлт	Нийт Дүн	
	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,178,011,263.2	
3	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	151,218,467.1	
4	Бусад дэлгэрэнгүй орлого	58,029,931.2	
5	Өмчид гарсан өөрчлөлт	81,111,690.9	
6	Хуваарилсан ногдол ашиг	-59,992,458.3	
	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,408,378,894.1	
3	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	174,144,582.4	
4	Бусад дэлгэрэнгүй орлого	3,490,273.9	
5	Өмчид гарсан өөрчлөлт	-134,778,727.7	
6	Хуваарилсан ногдол ашиг	-52,270,757.6	
	2024 оны 06-р сарын 30-ны үлдэгдэл	1,398,964,265.1	
		/Мянган төгрөг/	
№	Үзүүлэлт	Эцсийн үлдэгдэл	
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	***	
1.1	Орлогын татварын өмнөх ашиг (алдагдал)	188,234,896.5	
1.2	Орлого, зардлын тохируулга	(251,717,555.4)	
1.3	Хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн тохируулга	(679,039,459.5)	
1.4	Бусад тохируулга	317,308,998.9	
1.5	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(425,213,119.4)	
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	***	
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	882,912,114.6	
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(738,825,944.3)	
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	144,086,170.3	
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	***	
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,792,965,079.9	
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(1,922,680,595.6)	
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(129,715,515.7)	
4	Валютын ханшийн зөрүү	0.0	
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(410,842,464.8)	
6	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,867,167,489.0	
7	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,456,325,024.1	
2	<i>Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт</i>		
	Хавсралт 2 - ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны 2024 оны 7 сарын 4-ний өдрийн хурлаар ХХБ-ны 2024 оны хагас жилийн санхүүгийн тайланг хэлэлцэж гаргасан дүгнэлт		

3	<i>Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт</i>				
3.1.	<i>Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/</i>	Хавсралт 1 - Санхүүгийн нэгтгэсэн тайлан			
3.2.	<i>Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт</i>	№	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт	Байвал зохих	Банк
		1	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа	>9%	15.17%
		2	Өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа	>12%	15.17%
		3	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт	>25%	43.50%
		4	Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар)	<+/-15%	-6.11%
		5	Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт)	<+/-30	-10.86%
3.3.	<i>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл</i>				
<p>Эдийн засгийн өсөлт 2024 оны эхний улиралд 7.4 хувьтай гарлаа. Гадаад эрэлт тогтвортой байж, уул уурхайн бүтээгдэхүүний олборлолт өндөр байсан, үйлчилгээний салбарын идэвхжил нэмэгдсэн зэрэг нь эдийн засгийн өсөлтийг тэтгэв. Уг өсөлт банкны бүхий л үйл ажиллагаанд эергээр нөлөөллөө. Мөн Монголбанкнаас хэрэгжүүлж буй мөнгөний бодлогын үр дүнд инфляцын түвшин нэг оронтой тоонд орж, зорилтот инфляцын утга буюу 6.0%-д тогтворжсон нь бодит хүүг нэмэгдүүлж, харилцагчдын ахиу хадгалах хандлагыг нэмэгдүүлж байна. Нөгөө талаас МУ-ын 2024 оны төсвийн дагуу цалин, тэтгэмжийн хэмжээ өссөн нь иргэдийн зээлийн эрэлтийг давхар нэмэгдүүллээ. Банк уг эрэлтийг цахим зээлийн үйлчилгээгээр хүртээмжтэй хангаж ажилласан нь банкны иргэдийн сегмент хурдтай тэлэхэд чухал үүрэг гүйцэтгэв. Мөн Монголбанк 155,315 иргэн, ААН-ийн зээлийн түүхийн мэдээлэлд өөрчлөлт оруулсантай холбоотой зээлийн эрэлт нэмэгдсэн бөгөөд банк эрсдэлийн бодлогын хүрээнд уг эрэлтийг зохих түвшинд ханган ажиллаж байна. Үндэсний баялгийн сангийн тухай хууль батлагдаж, ипотекийн зээлийн санхүүжилт нэмэгдсэн нь тус зээлийн өсөлтийг эрчимжүүлэхээс гадна барилгын салбарыг идэвхжүүлэв. Гадаад валютын улсын нөөц анх удаа 5 тэрбум ам.долларыг давсан нь төгрөгийн ам.доллартой харьцах ханшийг чангаруулж байна. Энэ нь импортын зах зээлд эергээр нөлөөлж, иргэд, жижиг, дунд болон томоохон байгууллагуудын төлбөр тооцооны идэвхжилийг нэмэгдүүлэх хүчин зүйл болов. Мөн ХХБ нь АНУ-ын BNY Mellon банканд нээсэн ностро дансаар дамжуулан ам.долларын гүйлгээг хурдтай, хямд зардлаар гүйцэтгэж байна. Энэ нь банкны гадаад төлбөр тооцооны зах зээлд эзлэх хувийг хурдтай өсгөөд зогсохгүй хил дамнасан худалдаа, түүний төлбөр тооцоонд томоохон дэмжлэг үзүүлж, улмаар МУ-ын эдийн засгийн сэргэлтэд хувь нэмэр оруулж байна. Томоохон эдийн засгууд бенчмарк хүүгээ бууруулж эхэлсэн нь гадаадын банк, санхүүгийн байгууллагаас хямд өртөгтэй эх үүсвэр татах, өрийн хэрэгсэл арилжаалах татай нөхцөлийг бүрдүүлж байна. Түүнчлэн харилцагч зайнаас бүртгэх боломжийг бүрдүүлсэн холбогдох хууль, тогтоомжийн төслийг УИХ-аар хэлэлцүүлж, баталбал банкны шинэ харилцагч татах үйл ажиллагаанд эерэг нөлөө үзүүлэхээр хүлээгдэж байна.</p>					
Банкны зах зээлд эзлэх хувь:					
№	Үзүүлэлт	Зах зээлд эзлэх хувь			
		2023 он	2024 оны 5-р сар		
1	Актив	21.1%	20.3%		
2	Зээл	19.0%	18.7%		
3	Харилцагчдын харилцах, хадгаламж	23.2%	22.4%		
4	Илгээсэн гадаад шилжүүлэг	39.1%	42.3%		
<p>ХХБ нь эдийн засаг, бизнесийн идэвхжилт болон харилцагчдын зан төлөв, эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн уян хатан нөхцөл бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд тасралтгүй нэвтрүүлдэг бөгөөд 2024 онд үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, процессын дахин инженерчлэл хийх, цахимжуулалтыг эрчимжүүлэхэд түлхүү анхаарал хандуулж, банкны ашигт ажиллагааг нэмэгдүүлэхээр ажиллаж байна.</p>					
<p>Мөн банк нь харилцагчдынхаа хүсэл сонирхлыг хангах, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, санхүүгийн боловсролыг дэмжих зорилгоор үндэсний хэмжээний томоохон хөтөлбөрүүдээ амжилттай үргэлжлүүлж байна.</p>					
<ul style="list-style-type: none"> • “Бритто” лоялти экосистемийг амжилттай цогцлоож, цар хүрээгээ улам тэлсээр виза картын зах зээлд эзлэх хувиа тасралтгүй нэмэгдүүлж байна (2021 он: 13.9%, 2023 он: 29.0%). 					

	<ul style="list-style-type: none"> “Хуримтлалтай Монгол” аяныг амжилттай үргэлжлүүлж, иргэдийн санхүүгийн боловсролыг дэмжихээс гадна банкны тогтвортой эх үүсвэрийг тасралтгүй нэмэгдүүлж байна (аянд идэвхтэй хамрагдаж буй харилцагчдын тоо: 350,000). <p>Эцэст нь банк олон улсад тэргүүлэгч “Temenos Transact 24” суурь бүртгэлийн систем, “Temenos Infinity” дижитал банкны платформыг амжилттай нэвтрүүлж байна. Цаашид ХХБ технологийн шинэчлэлт, дижитал шилжилтийг үргэлжлүүлэн хийхийн зэрэгцээ харилцагч төвтэй бизнес загварын шилжилтийг бүрэн нэвтрүүлж, үйлчилгээний чанар, хурд, хүртээмжээ олон улсын жишигт нийцүүлэн сайжруулахаар төлөвлөж байна.</p>																																													
3.4.	<p><i>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого</i></p>																																													
	<p>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээг Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан А-294/340 тоот тушаал, “Банкны нягтлан бодох бүртгэлийн заавар”, Монголбанкны ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан А-155/134 тоот тушаалаар батлагдсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-уудын дагуу бүртгэж байна.</p> <table border="1" data-bbox="272 556 1425 655"> <thead> <tr> <th colspan="2">Тэнцлийн гадуурх данс</th> <th>MNT'000</th> </tr> </thead> <tbody> <tr> <td colspan="2">Зээл, зээлтэй адилтгах хөрөнгөд хамаарах үүрэг (цэвэр дүнгээр)</td> <td>1,268,030,702</td> </tr> </tbody> </table>	Тэнцлийн гадуурх данс		MNT'000	Зээл, зээлтэй адилтгах хөрөнгөд хамаарах үүрэг (цэвэр дүнгээр)		1,268,030,702																																							
Тэнцлийн гадуурх данс		MNT'000																																												
Зээл, зээлтэй адилтгах хөрөнгөд хамаарах үүрэг (цэвэр дүнгээр)		1,268,030,702																																												
4	<p><i>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</i></p>																																													
	<p>ХХБ нь Компанийн тухай хууль болон 2023 оны 2-р сард ТУЗ-өөс баталсан “ХХБ-ны сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийх журам”, 2023 оны 3-р сард Гүйцэтгэх захирлын тушаалаар баталсан “Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлэлцэл хийх заавар”-ыг тус тус мөрдөж ажилладаг.</p> <p>Тайлант хугацаанд ТУЗ-өөс 7 сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулахыг зөвшөөрсөн ба зөвшөөрөл олгосон тогтоолуудыг тухай бүрт холбогдох хууль тогтоомжид заасны дагуу олон нийтэд мэдээлсэн. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосон ТУЗ-ийн тогтоолуудтай дараах холбоосоор танилцана уу. https://www.mse.mn/mn/company/567</p> <p>Мөн, ТУЗ-өөс тайлант хугацаанаас өмнө олгосон зөвшөөрлийн дагуу 5 сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулсан.</p> <p>Банкны тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу банк нь холбогдох этгээдэд олгосон зээл, гаргасан аккредитив, бусад үүрэг, ажил, үйлчилгээний мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэлдэг.</p> <p>2024 оны 6-р сарын 30-ны байдлаар (сая төгрөгөөр)</p> <table border="1" data-bbox="191 1150 1464 1459"> <thead> <tr> <th colspan="2">Банкны холбогдох этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)</th> <th>Активын хэлбэр</th> <th>Үлдэгдэл дүн</th> <th>Өөрийн хөрөнгөд эзлэх хувь</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Банкны холбогдох нэг этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй)</td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>1.1.</td> <td>Банкны хувьцаа эзэмшигч</td> <td>Зээл, Авлага</td> <td>5,100.0</td> <td>0.36%</td> </tr> <tr> <td>1.2.</td> <td>Банкны эрх бүхий албан тушаалтан</td> <td>Зээл</td> <td>3,371.9</td> <td>0.24%</td> </tr> <tr> <td>1.3.</td> <td>Банкны бусад холбогдох этгээд</td> <td>Авлага</td> <td>41,770.3</td> <td>2.99%</td> </tr> <tr> <td>2.</td> <td>Банкны холбогдох нийт этгээд (нэгдмэл сонирхолтой этгээдүүд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй)</td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>2.1.</td> <td>Банкны хувьцаа эзэмшигчид</td> <td>Зээл, Авлага</td> <td>5,100.0</td> <td>0.36%</td> </tr> <tr> <td>2.2.</td> <td>Банкны эрх бүхий албан тушаалтанууд</td> <td>Зээл, Авлага</td> <td>4,991.7</td> <td>0.36%</td> </tr> <tr> <td>2.3.</td> <td>Банкны бусад холбогдох этгээд</td> <td>Зээл, Бусад актив</td> <td>88,656.6</td> <td>6.34%</td> </tr> </tbody> </table> <p>Тайлант хугацаанд Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1 дэх хэсэгт тодорхойлсон их хэмжээний хэлцэл байгуулаагүй болно.</p>	Банкны холбогдох этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)		Активын хэлбэр	Үлдэгдэл дүн	Өөрийн хөрөнгөд эзлэх хувь	1	Банкны холбогдох нэг этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй)				1.1.	Банкны хувьцаа эзэмшигч	Зээл, Авлага	5,100.0	0.36%	1.2.	Банкны эрх бүхий албан тушаалтан	Зээл	3,371.9	0.24%	1.3.	Банкны бусад холбогдох этгээд	Авлага	41,770.3	2.99%	2.	Банкны холбогдох нийт этгээд (нэгдмэл сонирхолтой этгээдүүд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй)				2.1.	Банкны хувьцаа эзэмшигчид	Зээл, Авлага	5,100.0	0.36%	2.2.	Банкны эрх бүхий албан тушаалтанууд	Зээл, Авлага	4,991.7	0.36%	2.3.	Банкны бусад холбогдох этгээд	Зээл, Бусад актив	88,656.6	6.34%
Банкны холбогдох этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)		Активын хэлбэр	Үлдэгдэл дүн	Өөрийн хөрөнгөд эзлэх хувь																																										
1	Банкны холбогдох нэг этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй)																																													
1.1.	Банкны хувьцаа эзэмшигч	Зээл, Авлага	5,100.0	0.36%																																										
1.2.	Банкны эрх бүхий албан тушаалтан	Зээл	3,371.9	0.24%																																										
1.3.	Банкны бусад холбогдох этгээд	Авлага	41,770.3	2.99%																																										
2.	Банкны холбогдох нийт этгээд (нэгдмэл сонирхолтой этгээдүүд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй)																																													
2.1.	Банкны хувьцаа эзэмшигчид	Зээл, Авлага	5,100.0	0.36%																																										
2.2.	Банкны эрх бүхий албан тушаалтанууд	Зээл, Авлага	4,991.7	0.36%																																										
2.3.	Банкны бусад холбогдох этгээд	Зээл, Бусад актив	88,656.6	6.34%																																										
5	<p><i>Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл</i></p>																																													
	<p>Худалдаа, хөгжлийн банк ("ХХБ") нь татан төвлөрүүлсэн хөрөнгийг дунд хугацааны Бизнес төлөвлөгөөний зорилгоо хэрэгжүүлэх ажлын хүрээнд банкны үндсэн бүтээгдэхүүн болох зээл олголтод зарцуулахаар төлөвлөсөн билээ. Ингэхдээ "Ногоон банк" болох урт хугацааны тэргүүлэх дэд стратеги чиглэлийн хүрээнд ХХБ-ны "Тогтвортой санхүүжилтийн хүрээ" баримт бичигт тусгагдсан ногоон болон нийгмийн зээлийн ангиллуудад уялдуулан санхүүжилт олгох юм. Анхдагч зах зээлийн арилжаанд нийт 2'528 хөрөнгө оруулагчдаас 105.5 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий захиалга хүлээн авч, татан төвлөрүүлэх зорилгот дүн болох 83.5 тэрбум төгрөгийн захиалга 126.4% гүйцэтгэлтэйгээр хаагдсан.</p> <p>Банк нь активын зохистой бүтцийг бий болгох, иргэд болон жижиг, дунд бизнесийн зах зээлд тэлэлт хийх стратеги төлөвлөгөөний дагуу татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтыг бизнесийн сегментүүдэд дараах хуваариар төлөвлөсөн байна. Үүнд:</p> <p>I. Байгууллагын сегмент: 50.0% II. Жижиг, дунд бизнесийн сегмент: 20.0% III. Иргэдийн сегмент: 30.0%</p>																																													


Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт 2024.06.30-ны өдрийн байдлаар 86.83%-ийн ашиглалттай байгаа ба үүнд Жижиг, дунд бизнесийн сегмент болон Иргэдийн сегментүүд хуваарилагдсан тус эх үүсвэрийг зориулалтын дагуу бүрэн зарцуулж дууссан бол Байгууллагын сегментэд нийт 50.0%-иас 36.8%-ийн эх үүсвэрийн зарцуулалтын төлөвтэй байна.

6 *Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл*
Хавсралт 3


7 *Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл*

<p style="text-align: center;">Дотоодын эдийн засгийг дэмжсэн нийгмийн ажлууд</p> <div style="display: flex; justify-content: space-between;"> <div style="width: 45%;">  <p>World Economic Forum 2024 "Давос 2024" дэлхийн эдийн засгийн чүүлгэнд ХХБ-ны ТУЗ-ийн дарга Рандолф Коппа оролцлоо. Тэрээр "Монгол Улс ФАТФ-ын саарал жагсаалтад орсноосоо хойш эргэн дэлхийн амдолларын төлбөрийн системд нэгдсэн нь дэлхийн улс орнууд Монгол Улстай бизнес хийх итгэлийг нэмэгдүүлнэ" гэдгийг онцоллоо.</p> </div> <div style="width: 45%;">  <p>Global Gateway project Монгол Улс болон Европын улс орнуудын хооронд дахь бизнес харилцаа, камтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд Европ Монголын хамтарсан Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас зохион байгуулсан Global Gateway project - opportunities for companies in Mongolia" арга хэмжээнд Platinum Sponsor-р оролцлоо.</p> </div> </div> <div style="display: flex; justify-content: space-between; margin-top: 20px;"> <div style="width: 45%;">  <p>Trade Finance Forum 2024 Уламжлал болсон худалдааны санхүүжилтийн форуммаа зохион байгууллаа. Худалдаа, үйлчилгээний бизнесийн орчныг шинээр харж, сорилт бархшээл, амжилт ололт, шинэ боломжийг хүндэт харилцагч, бизнесийн итгэлт түншүүдтэйгээ хамт хэлэлцлээ.</p> </div> </div>	<p style="text-align: center;">Байгаль орчин, нийгэмд чиглэсэн</p> <div style="display: flex; justify-content: space-between;"> <div style="width: 45%;">  <p>Boundless Dream "Хязгааргүй мөрөөдөл" төслөө Дэлхийн Аутизмын сарыг тохиолдуулан аутизмтай онцгой хүүхдүүдэд зориулан хэрэгжүүлээ. Ингэхдээ Аутизм ба Бусад Онцгой Хүүхдүүдийн Академид "хүүхдүүд дурд орж тоглох сургалтын өрөөг иж бүрэн тохижуулж" өгсөн. Тус сургалтын өрөөг байгуулснаар хүүхдүүд кэл ариа, харилцааны хувьд хөгжиж, нийгмийн харилцаанд ороход нь хэрэгтэй юм.</p> </div> <div style="width: 45%;">  <p>Steamex Монголд анх удаа олон улсын хамгийн том боловсролын арга хэмжээ болох STEAMEX 2024 зохион байгуулагдсан. Тус арга хэмжээний үеэр бага ангийн болон байгалийн ухааны багш нарыг чадавхжуулах 100% практик гуршилт, бүтээлд сүүрилсэн хөтөлбөрт 21 аймаг бүрээс оролцох 100 багийн төлбөрийг төллөө.</p> </div> </div> <div style="display: flex; justify-content: space-between; margin-top: 20px;"> <div style="width: 45%;">  <p>Тогоо гохируулья аян Эрчим хүчний зохистой хэрэглээг дэмжих "ТОГ-оо тохируулья" аянд нэгдэж банкны ажилтнууд болон харилцагч нараа тогоо тохируулан нэгдэхийг уриаллаа. Бид эрчим хүчний зохистой хэрэглээний соёлыг түгээн дэлгэрүүлэхийн зэрэгцээ хэрэглээгээ багасгахын тулд байгууллага дээрх гэрэл цахилгаан хэрэглээг цахилгаан зарцуулалт бага хэрэглээр сольж, эрчим хүчний өндөр хэрэглээтэй цахилгаан хэрэглээг ачаалал багатай үед ажиллуулж байна.</p> </div> </div>
--	--

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: **О.ОРХОН**
Албан тушаал: **ГҮЙЦАГЦЭХ ЗАХИРАЛ**
Гарын үсэг: 

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо

Овог, нэр: **Н.НЯМСҮРЭН**
Албан тушаал: **ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА**
Гарын үсэг: 

Байгууллагын нэр: Худалдаа хөгжлийн банк
Регистр: 2635534

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

/Мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл (2023.12.31)	Эцсийн үлдэгдэл (2024.06.30)
1	ХӨРӨНГӨ	0.0	0.0
1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	3,867,167,489.0	3,456,325,024.1
1.1.1	Бэлэн мөнгө	68,202,440.3	96,182,447.9
1.1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө	2,839,863,505.2	2,032,409,618.9
1.1.3	Мөнгөтэй адилтгах хөрөнгө	955,865,808.8	1,325,210,927.6
1.1.4	Мөнгөн хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	3,235,734.7	2,522,029.7
1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	1,049,226,841.3	1,569,769,294.3
1.2.1	Монголбанкинд байршуулсан хөрөнгө	1,049,656,108.4	1,570,198,561.4
1.2.2	Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	0.0	0.0
1.2.3	Бусад хөрөнгө	0.0	0.0
1.2.4	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	0.0	0.0
1.2.5	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн эрсдэлийн сан	-429,267.1	-429,267.1
1.3	Хөрөнгө оруулалт	967,259,402.4	779,148,249.8
1.3.1	Арилжааны үнэт цаас	0.0	0.0
1.3.2	Борлуулахад бэлэн үнэт цаас	931,422,293.5	749,250,264.0
1.3.3	Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас	0.0	0.0
1.3.4	Зээл ба авлага гэж ангилсан бусад үнэт цаас	0.0	0.0
1.3.5	Хараат, хамтын хяналттай, охин компанид оруулсан хөрөнгө оруулалт	5,196,223.0	5,196,223.0
1.3.6	Барьцаанд байгаа үнэт цаас	0.0	0.0
1.3.7	Үнэт цаасанд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	30,656,400.9	24,717,277.8
1.3.8	Үнэт цаасны эрсдэлийн сан	-15,515.0	-15,515.0
1.4	Зээл (цэвэр дүнгээр)	4,933,457,222.6	5,586,904,295.6
1.4.1	Хэвийн зээл	4,232,500,717.5	5,070,941,528.4
1.4.2	Хугацаа хэтэрсэн зээл	361,745,446.4	408,938,196.2
1.4.3	Хэвийн бус зээл	98,094,237.3	28,623,274.6
1.4.4	Эргэлзээтэй зээл	122,352,069.1	105,750,426.7
1.4.5	Муу зээл	339,800,150.1	295,696,404.9
1.4.6	Зээлийн хойшлогдсон төлбөр	-8,890,827.4	-8,890,827.4
1.4.7	Зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	199,842,821.3	146,812,258.4
1.4.8	Зээлийн эрсдэлийн сан	-411,987,391.7	-460,966,966.3
1.5	Дериватив санхүүгийн хөрөнгө	172,188,576.6	50,068,792.7
1.6	Бусад санхүүгийн хөрөнгө	163,492,442.1	163,573,927.9
1.6.1	Бусад санхүүгийн хөрөнгө	130,963,553.7	137,559,786.1
1.6.2	Банк, салбар хоорондын тооцоо	29,370,837.2	23,389,656.5
1.6.3	Өмчлөх бусад хөрөнгө (цэвэр дүнгээр)	0.0	0.0
1.6.4	Бусад	3,158,051.2	2,624,485.2
1.7	Бусад санхүүгийн бус хөрөнгө	345,746,019.5	218,688,232.6
1.7.1	Бусад тооцоо	30,097,273.7	44,885,207.9
1.7.2	Бараа материал, үнэ бүхий зүйл	5,151,016.0	7,575,554.6
1.7.3	Үнэт металл (цэвэр дүнгээр)	24,703,648.8	84,657.0
1.7.4	Өмчлөх бусад хөрөнгө (цэвэр дүнгээр)	284,291,614.4	164,449,544.5
1.7.5	Татварын авлага	1,501,698.5	1,501,698.5
1.7.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	0.0	0.0
1.7.7	Бусад	768.1	191,570.1
1.8	Үндсэн хөрөнгө	581,214,456.8	569,736,899.7
1.9	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	53,256,860.0	56,759,674.3
1.10	Борлуулах зориулалттай хөрөнгө	8,259,130.1	136,772,380.8
1.11	Биет бус хөрөнгө	25,308,105.0	38,289,151.7
1.12	Нийт хөрөнгийн дүн	12,166,576,545.4	12,626,035,923.4
2	ӨР ТӨЛБӨР	0.0	0.0
2.1	Харилцах	3,913,330,516.8	3,718,189,143.7

2.1.1	Харилцах дансны нэрлэсэн үлдэгдэл	3,913,329,939.0	3,718,188,591.6
2.1.2	Харилцах дансанд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	577.8	552.2
2.2	Хадгаламж	4,594,267,409.6	4,790,168,315.9
2.2.1	Хугацаагүй хадгаламж	504,899,398.1	643,448,211.6
2.2.2	Хугацаатай хадгаламж	3,973,579,336.0	3,988,147,595.5
2.2.3	Бусад төрлийн хадгаламж	782,138.0	3,320,000.0
2.2.4	Хадгаламжинд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	115,006,537.5	155,252,508.8
2.3	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	1,669,206,994.4	2,207,732,902.1
2.3.1	Банк, санхүүгийн байгууллагаас байршуулсан харилцах, хадгаламж	836,004,691.5	852,435,811.6
2.3.2	Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл (хугацаа хэтэрсэн зээлийн дүнг оруулсан)	794,115,155.5	1,300,411,180.4
2.3.3	Эх үүсвэрийн хойшлогдсон төлбөр	-376,189.5	-243,241.3
2.3.4	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	39,463,336.9	55,129,151.4
2.4	Бусад эх үүсвэр	152,377,331.9	212,164,499.6
2.4.1	Банкнаас гаргасан ерийн бичиг	0.0	0.0
2.4.2	Банкнаас гаргасан үнэт цаас	0.0	0.0
2.4.3	Төслийн зээлийн санхүүжилт	41,045,873.5	42,340,791.7
2.4.4	Буцаан худалдан авах нөхцөлөөр худалдсан үнэт цаас (репо)	45,590,568.3	82,596,561.0
2.4.5	Хамтын зээлжүүлэлтийн эх үүсвэр	0.0	0.0
2.4.6	Бусад	59,989,736.0	78,956,702.0
2.4.7	Бусад эх үүсвэрийн хойшлогдсон төлбөр	0.0	0.0
2.4.8	Бусад эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	5,751,154.1	8,270,444.9
2.5	Дериватив санхүүгийн өр төлбөр	159,109,749.3	20,088,851.5
2.6	Бусад санхүүгийн өр төлбөр	177,218,603.1	207,138,535.7
2.7	Бусад санхүүгийн бус өр төлбөр	92,687,046.2	71,589,409.7
2.8	Хоёрдогч өглөг	0.0	0.0
2.9	Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр)	0.0	0.0
2.10	Нийт өр төлбөрийн дүн	10,758,197,651.3	11,227,071,658.3
3	ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	0.0	0.0
3.1	Хувь нийлүүлсэн хөрөнгө	340,852,904.4	340,852,904.4
3.1.1	Давуу эрхийн хувьцаа	0.0	0.0
3.1.2	Энгийн хувьцаа	340,852,904.4	340,852,904.4
3.2	Нэмж төлөгдсөн капитал	64,069,779.4	64,069,779.4
3.3	Халаасны хувьцаа	0.0	0.0
3.4	Дахин үнэлгээний нэмэгдэл	143,479,413.2	139,303,196.0
3.5	Хуримтлагдсан ашиг, алдагдал	689,288,519.2	813,342,605.0
3.6	Бусад өөрийн хөрөнгө	170,688,277.9	41,395,780.4
3.6.1	Хувьцааны опцион	0.0	0.0
3.6.2	Нөөцийн сан	494,515.5	494,515.6
3.6.3	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.0	0.0
3.6.4	Эрсдэлийн сангийн нөөц	134,778,727.7	0.0
3.6.5	Нийгмийн хөгжлийн сан	0.0	0.0
3.6.6	Хувьцаанд хөрвөх үнэт цаас (өөрийн хөрөнгө)	0.0	0.0
3.6.7	Хувьцаанд хөрвөх эх үүсвэр (өөрийн хөрөнгө)	0.0	0.0
3.6.8	Борлуулахад бэлэн үнэт цаасны дахин үнэлгээний сан	35,415,034.7	0.0
3.6.9	Хейджийн хэрэгслийн дахин үнэлгээний сан	0.0	0.0
3.6.10	Бусад	0.0	40,901,264.9
3.7	Өөрийн хөрөнгийн дүн	1,408,378,894.1	1,398,964,265.1
4	Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	12,166,576,545.4	12,626,035,923.4

Байгууллагын нэр: Худалдаа хөгжлийн банк

Регистр: 2635534

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

/Мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл (2023.12.31)	Эцсийн үлдэгдэл (2024.06.30)
1	Хүүгийн орлого	764,712,399.4	511,463,096.3
1.1	Монголбанкинд байршуулсан хөрөнгийн	41,860,603.6	25,966,029.5
1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн	35,335,322.8	26,823,298.5
1.3	Үнэт цаасны	173,619,149.6	125,705,856.9
1.4	Зээлийн	513,897,323.4	332,967,911.5
1.5	Бусад хүүгийн орлого	0.0	0.0
2	Хүүгийн зардал	469,048,440.4	282,155,777.4
2.1	Харилцахад төлсөн хүү	37,883,523.9	29,506,639.3
2.2	Хадгаламжинд төлсөн хүү	339,751,292.0	217,412,476.9
2.3	Зээлийн хүүгийн зардал	78,350,667.0	32,491,425.1
2.4	Үнэт цаасны хүүгийн зардал	10,962,353.7	2,744,583.8
2.5	Бусад хүүгийн зардал	2,100,603.8	652.3
3	ЦЭВЭР ХҮҮГИЙН ОРЛОГО(1-2)	295,663,959.0	229,307,318.9
4	Эрсдэлийн сангийн зардал	78,768,202.1	17,254,328.9
4.1	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн	0.0	0.0
4.2	Үнэт цаасны	171,520.1	0.0
4.3	Зээлийн	78,596,682.0	17,254,328.9
5	Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого [(3)-(4)]	216,895,756.9	212,052,990.1
6	Бусад орлого	224,577,343.6	175,445,985.5
6.1	Хүүгийн бус орлого	213,991,794.8	173,282,898.4
6.1.1	Арилжааны орлого	43,917,804.9	23,449,573.1
6.1.2	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого	1,563,764.0	24,818,045.4
6.1.3	Банкны бүтээгдэхүүнтэй холбоотой үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	94,497,318.6	67,001,362.3
6.1.4	Бусад хүүгийн бус орлого	74,012,907.3	58,013,917.7
6.2	Бусад орлого, олз	10,585,548.8	2,163,087.1
7	Бусад зардал	244,666,919.6	199,264,079.0
7.1	Хүүгийн бус зардал	242,183,648.9	197,045,612.4
7.1.1	Бусад эрсдэлийн сангийн зардал	17,821,155.9	67,969,135.1
7.1.2	Арилжааны зардал	1,091,075.7	1,300,130.6
7.1.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн зардал	8,835,292.0	0.0
7.1.4	Хураамж, шимтгэлийн зардал	38,800,035.5	21,951,324.3
7.1.5	Үйл ажиллагааны бусад зардал	175,636,089.8	105,825,022.4
7.2	Бусад зардал, гарз	2,483,270.7	2,218,466.7
8	Татварын өмнөх ашиг, алдагдал (5+6-7)	196,806,180.9	188,234,896.5
9	Орлогын татварын зардал	45,587,713.8	14,090,314.1
10	Татварын дараах ашиг, алдагдал (8-9)	151,218,467.1	174,144,582.4
11	Зогсоосон үйл ажиллагааны цэвэр орлого, зардал	0.0	0.0
12	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал (10+11)	151,218,467.1	174,144,582.4
13	Бусад дэлгэрэнгүй орлого	58,029,931.2	1,310,012.9
13.1	Үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны өсөлт, бууралт	-2,172,038.9	-4,176,217.2
13.2	Борлуулахад бэлэн үнэт цаасны дахин үнэлгээний өсөлт, бууралт	60,201,970.1	5,486,230.1
14	Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлогын дүн (12+13)	209,248,398.3	175,454,595.4

№	Тэнцлийн гадуурх данс	/Мянган төгрөг/
1	Зээл, зээлтэй адилтгах хөрөнгөд хамаарах үүрэг (цэвэр дүнгээр)	1,268,030,702

Байгууллагын нэр: Худалдаа хөгжлийн банк
Регистр: 2635534

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл (2023.12.31)	Эцсийн үлдэгдэл (2024.06.30)
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	***	***
1.1	Орлогын татварын өмнөх ашиг (алдагдал)	196,806,180.9	188,234,896.5
1.2	Орлого, зардлын тохируулга	(337,283,219.1)	(251,717,555.4)
1.2.1	Эрсдэлийн сангийн зардал (+)	(53,967,334.3)	(30,795,579.4)
1.2.2	Элэгдэл, хорогдлын зардал (+)	12,348,074.2	8,385,343.0
1.2.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого (-), зардал (+) (Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөөс бусад)	0.0	0.0
1.2.4	Хуримтлуулсан хүүгийн орлого (-)	(764,712,399.4)	(511,463,096.3)
1.2.5	Хуримтлуулсан хүүгийн зардал (+)	469,048,440.4	282,155,777.4
1.2.6	Хөрөнгө данснаас хассаны олз (-), гарз (+)	0.0	0.0
1.2.7	Бусад олз (-), гарз (+)	0.0	0.0
1.3	Хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн тохируулга	1,527,175,090.6	(679,039,459.5)
1.3.1	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)	(224,504,824.3)	(520,367,498.9)
1.3.2	Арилжааны үнэт цаасны өсөлт (-), бууралт (+)	0.0	0.0
1.3.3	Зээлийн өсөлт (-), бууралт (+)	(1,084,599,374.7)	(817,729,043.2)
1.3.4	Бусад санхүүгийн хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)	291,042,635.4	159,712,106.1
1.3.5	Бусад санхүүгийн бус хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)	(21,153,630.7)	9,834,588.4
1.3.6	Харилцах, хадгаламжийн өсөлт (+), бууралт (-)	2,433,000,143.1	(39,486,412.4)
1.3.7	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн өсөлт (+), бууралт (-)	(14,890,405.3)	597,895,273.1
1.3.8	Бусад санхүүгийн өр төлбөрийн өсөлт (+), бууралт (-)	70,448,598.9	(96,489,971.7)
1.3.9	Бусад санхүүгийн бус өр төлбөрийн өсөлт (+), бууралт (-)	77,831,948.1	27,591,499.2
1.4	Бусад тохируулга	303,296,238.3	317,308,998.9
1.4.1	Авсан хүү (+)	772,766,340.8	556,973,809.9
1.4.2	Төлсөн хүү (-)	(423,882,388.7)	(225,574,496.9)
1.4.3	Орлогын татварын төлөлт (-)	(45,587,713.8)	(14,090,314.1)
1.4.4	Эрсдэлийн сангаас хаасан зээл, авлага (-)	0.0	0.0
1.4.5		0.0	0.0
1.5	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,689,994,290.7	(425,213,119.4)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	***	***
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,531,046,210.6	882,912,114.6
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	86,076,764.5	41,833,472.8
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	3,053,935.2	0.0
2.1.3	Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө борлуулсны орлого	40,936,017.0	2,478,545.6
2.1.4	Охин компани, хараат компани, хамтын хяналттай аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0.0	0.0
2.1.5	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	0.0	0.0
2.1.6	Зээл ба авлага гэж ангилан хорогдуулсан өртгөөр бүртгэсэн хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0.0	0.0
2.1.7	Борлуулахад бэлэн үнэт цаас борлуулсны орлого	1,518,798,414.0	295,755,277.1
2.1.8	Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас борлуулсны орлого	654,692,710.9	365,565,803.5
2.1.9	Хүлээн авсан ногдол ашиг	0.0	0.0
2.1.10	Бусад мөнгөн орлого	227,488,369.0	177,279,015.6
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(2,691,098,117.1)	(738,825,944.3)
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	181,822,895.3	108,694,415.9
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	27,856,592.1	10,453,948.4
2.2.3	Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	5,753,185.6	0.0
2.2.4	Охин компани, хараат компани, хамтын хяналттай аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	4,689,926.1	4,271,538.2

2.2.5	Зээл ба авлага гэж ангилан хорогдуулсан өртгөөр бүртгэсэн хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0.0	0.0
2.2.6	Борлуулахад бэлэн үнэт цаас олж эзэмшихэд төлсөн	1,588,876,902.1	464,439,868.9
2.2.7	Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас олж эзэмшихэд төлсөн	692,218,871.9	16,409,182.2
2.2.8	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.0	0.0
2.2.9	Бусад мөнгөн зарлага	189,879,744.0	134,556,990.7
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(160,051,906.5)	144,086,170.3
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	***	***
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	4,158,536,043.6	1,792,965,079.9
3.1.1	Бусад эх үүсвэр татаж хүлээн авсан	2,822,912,720.6	1,683,828,439.2
3.1.2	Хоёрдогч өглөгөөс хүлээн авсан	0.0	0.0
3.1.3	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.0	0.0
3.1.4	Төрөл бүрийн хандив	0.0	0.0
3.1.5	Бусад	1,335,623,323.0	109,136,640.7
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(4,323,655,038.2)	(1,922,680,595.6)
3.2.1	Бусад эх үүсвэрт төлсөн	3,092,822,144.6	1,701,595,742.1
3.2.2	Хоёрдогч өглөгт төлсөн	0.0	0.0
3.2.3	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.0	0.0
3.2.4	Хувьцаа буцаан худалдан авахад төлсөн	(17,042,601.5)	0.0
3.2.5	Төлсөн ногдол ашиг	0.0	0.0
3.2.6	Бусад	1,247,875,495.1	221,084,853.5
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(165,118,994.6)	(129,715,515.7)
4	Валютын ханшийн зөрүү	0.0	0.0
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,364,823,389.6	(410,842,464.8)
6	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,502,344,099.4	3,867,167,489.0
7	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,867,167,489.0	3,456,325,024.1

Байгууллагын нэр: Худалдаа хөгжлийн банк
 Регистр: 2635534
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/Мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Нэмж төлөгдсөн капитал	Халаасны хувьцаа	Дахин үнэлгээний нэмэгдэл	Бусад өөрийн хөрөнгө	Хуримт-лагдсан ашиг	Нийт Дүн
	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	323,810,302.8	690.1	0.0	145,651,452.1	113,752,043.1	594,796,775.1	1,178,011,263.2
1	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2	Залруулсан үлдэгдэл	323,810,302.8	690.1	0.0	145,651,452.1	113,752,043.1	594,796,775.1	1,178,011,263.2
3	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	0.0	0.0	0.0	0.0	0.0	151,218,467.1	151,218,467.1
4	Бусад дэлгэрэнгүй орлого	0.0	0.0	0.0	0.0	32,409,622.0	25,620,309.2	58,029,931.2
5	Өмчид гарсан өөрчлөлт	17,042,601.6	64,069,089.3	0.0	0.0	24,526,612.8	-24,526,612.8	81,111,690.9
6	Хуваарилсан ногдол ашиг	0.0	0.0	0.0	0.0	0.0	-59,992,458.3	-59,992,458.3
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.0	0.0	0.0	-2,172,038.9	0.0	2,172,038.9	0.0
	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	340,852,904.4	64,069,779.4	0.0	143,479,413.2	170,688,277.9	689,288,519.2	1,408,378,894.1
1	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2	Залруулсан үлдэгдэл	340,852,904.4	64,069,779.4	0.0	143,479,413.2	170,688,277.9	689,288,519.2	1,408,378,894.1
3	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	0.0	0.0	0.0	0.0	0.0	174,144,582.4	174,144,582.4
4	Бусад дэлгэрэнгүй орлого	0.0	0.0	0.0	-1,995,956.2	5,486,230.1	0.0	3,490,273.9
5	Өмчид гарсан өөрчлөлт	0.0	0.0	0.0	0.0	-134,778,727.6	0.0	-134,778,727.7
6	Хуваарилсан ногдол ашиг	0.0	0.0	0.0	0.0	0.0	-52,270,757.6	-52,270,757.6
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.0	0.0	0.0	-2,180,261.0	0.0	2,180,261.0	0.0
	2024 оны 06-р сарын 30-ны үлдэгдэл	340,852,904.4	64,069,779.4	0.0	139,303,196.0	41,395,780.4	813,342,605.0	1,398,964,265.1

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ
АУДИТЫН ХОРООНЫ ДҮГНЭЛТ

2024 оны 07 дугаар сарын 04

Улаанбаатар хот

Санхүүгийн тайлангийн хагас жилийн үзүүлэлтүүдтэй танилцлаа. Худалдаа хөгжлийн банк нь 2024 оны эний хагас жилд 12.6 их наяд төгрөгийн активтай, 187 тэрбум төгрөгийн татварын өмнөх ашигтай, Монголбанкнаас тогтоосон санхүүгийн шалгуур үзүүлэлтүүдийг хангасан, чанаргүй актив буурсан, цэвэр хүүний маржин өссөн, үйл ажиллагаа сайжирсан эерэг үзүүлэлтүүдтэй байна. Түүнчлэн банкны зах зээлд эзлэх хувь өсч байгаа нь банкны хувьд томоохон эерэг үзүүлэлт хэмээн үзлээ. Банк нь 2024 оны эхний хагасд ТУЗ-өөс өгсөн 2024 оны санхүүгийн төсөв, төлөвлөгөөг биелүүлсэн үйл ажиллагааны үр дүнгийн хувьд хангалттай ажилласан байна.

Мөн Аудитын хорооноос 2024 оны хагас жилийн санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлантай танилцаж, компанийн санхүүгийн тайлангийн тоон үлдэгдлүүд нь Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бодитоор илэрхийлэгдсэн гэж дүгнэлээ.

АУДИТЫН ХОРООНЫ ДАРГА



Ж.ДЭЛГЭРСАЙХАН

Компанийн засаглал

Худалдаа, хөгжлийн банк ХК (цаашид “ХХБ” эсхүл “Банк” гэх) нь Компанийн засаглалын чиглэлээрх бодлого, дүрэм, журам, заавруудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон засаглалын үнэлгээг оновчтой, бодитоор гаргаж, хөрөнгө оруулагч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах, урт хугацаанд үнэ цэнэ бүтээхэд дэмжлэг үзүүлэх, дотоодын төдийгүй олон улсын сайн туршлагыг нутагшуулан ТУЗ болон банкны бүхий л нэгжид хүрч, банкны стратеги төлөвлөгөө, байгууллагын бүтэц, бодлогыг тодорхойлон, оролцогч талуудын үнэ цэнийг нэмэгдүүлэхэд өндөр ач холбогдол өгч ажилладаг.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ



Хувьцаа эзэмшигчдийг эрх тэгш байдлаар хангах үүднээс Хөрөнгө оруулагчтай харилцах хөтөлбөрийг Төлөөлөн удирдах зөвлөлөөр баталсан төдийгүй ХХБ-ны дүрэмд хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхийг тусгасан нь эзэмшлийн хэмжээнээс үл хамааран эрх тэгш, ил тод нээлттэй мэдээллийг авах нөхцөлийг бий болгон ажиллаж байна.

Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон холбогдох зохицуулагч байгууллагуудаас баталсан журмуудад бүх хувьцаа эзэмшигчдийг мэдээллийг ижил хэмжээнд хүлээн авах, санал өгөх эрхийг хамгаалсан зохицуулалтууд нарийвчлан тусгасан байдаг. Ийнхүү хувьцаа эзэмшигч бүрт эрх тэгш үйлчлэх, харилцах зарчмуудыг тодорхойлохоос гадна хувьцаа эзэмшигчидтэй тухайлан харилцах Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх ажлын албыг бий болгосон нь байгууллагын хариуцлага, засаглалыг дэмжиж үр ашигтай байдлаар холбогдох сувгаар дамжуулан санал хүсэлт, харилцан мэдээлэл солилцох итгэлцэл болон оролцоог нэмэгдүүлэн, нийтлэг ашгийг хамгаалж, тогтвортой нээлттэй харилцааг өргөжүүлэн ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)

ХХБ нь ТУЗ-ийг олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, ашиг сонирхлын зөрчил, хараат бус байдал, хүйсийн тэнцвэр зэргийг зохистойгоор хангасан гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр бүтээлч, үр дүнтэй бүтэцтэй байлгахыг зорьдог ба Хувьцаа эзэмшигчдийн хурлаар сонгон томилно.

ТУЗ-ийн гишүүдийн жагсаалт		
Нэр	Албан тушаал	Харьяалал
Рандолф Коппа	ТУЗ-ийн дарга	Америкийн Нэгдсэн Улс
Жалбаагийн Болормаа	Хараат бус гишүүн	Монгол Улс
Жамсрандоржийн Дэлгэрсайхан	Хараат бус гишүүн	Монгол Улс
Загдхүүгийн Нарантуяа	Хараат бус гишүүн	Монгол Улс
Должингийн Эрдэнэбилэг	Гишүүн	Монгол Улс
Дамбийжавын Хүрэлбаатар	Гишүүн	Монгол Улс
Дагмидын Янжмаа	Гишүүн	Монгол Улс
Авгааны Энхмэнд	Гишүүн	Монгол Улс
Дэмчигжавын Отгонбилэг	Гишүүн	Монгол Улс

Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Банкны эрх барих дээд нэгжийн хувьд жендерийн эрх тэгш байдлыг эрхэмлэн үзэж, шийдвэр гаргах түвшинд оролцооны эрх тэгш харьцааг хангахыг зорьж, ХХБ-ны дүрэмд ТУЗ нь 9 гишүүнтэй, үүний 1/3 хараат бус гишүүнт байхаар Компанийн тухай хууль, Банкны тухай хуулийг мөрдлөг болгон баталсан нь сайн засаглалын зарчмыг хэрэгжүүлэх, ТУЗ-ийн шийдвэр гаргалтад хараат бус гишүүдийг оролцоо, бие даасан байдлыг хангахад гол чиглүүлэгч болдог.

ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийн хугацаа сонгогдсоноор эхэлж, түүнийг ТУЗ-ийн гишүүний үүрэгт ажлаас чөлөөлснөөр дуусгавар болно. Банкны ТУЗ-ийн гишүүд нь ердийн болон хараат бус гишүүнд тавигддаг тусгайлан шаардлагуудыг хангасан нь олон жилийн туршлагатай, банкныг удирдан чиглүүлэхэд мэдлэг ур, чадвар, боловсрол, ёс зүйн болон бизнесийн нэр хүндийн хувьд нийцсэн гэдгийг харуулж байна.

ТУЗ-ийн дэргэдэх хороод

ТУЗ нь дэргэдээ Цалин, урамшууллын болон нэр дэвшүүлэх хороо, Аудитын хороо болон Эрсдэлийн удирдлагын хороо гэсэн байнгын хороодтой ба эдгээр хороод нь хараат бус гишүүдээр даргалуулж, банкны удирдлага болон ажилтнаас бүрэлдэхүүнд байдаггүй нь ТУЗ-ийн шийдвэр гаргалтад бие даасан байдлыг бий болгох зарчмыг хангаж байгаа төдийгүй хороод үйл ажиллагаагаа зохион байгуулах, зохицуулах журам заавартай ба ТУЗ болон шаардлагатай тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хуралд ажлаа тайлагнахаар заасан байна. 2024 оны 2 сард Монгол Улсдаа анх удаа ТУЗ-ийн дэргэд банкны үйл ажиллагаа, тогтвортой санхүүжилт, байгаль орчин, нийгэм засаглалын чиглэлээр дэмжлэг, зөвлөмж өгөх чиг үүрэг бүхий Тогтвортой хөгжлийн хороог байгуулсан.

Хорооны нэр	Хорооны дарга	Хорооны гишүүд
Цалин, урамшууллын болон нэр дэвшүүлэх хороо	Ж.Болормаа ТУЗ-ийн хараат бус гишүүн	З.Нарантуяа ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Янжмаа ТУЗ-ийн гишүүн
Аудитын хороо	Ж.Дэлгэрсайхан ТУЗ-ийн хараат бус гишүүн	Ж.Болормаа ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Отгонбилэг ТУЗ-ийн гишүүн
Эрсдэлийн удирдлагын хороо	З.Нарантуяа ТУЗ-ийн хараат бус гишүүн	Ж.Дэлгэрсайхан ТУЗ-ийн хараат бус гишүүн Рандолф Коппа ТУЗ-ийн дарга

Цалин урамшууллын болон нэр дэвшүүлэх хороо (ЦУНДХ)

ЦУНДХ нь ХХБ-ны ТУЗ-ийн хяналт, удирдлагын үүргээ үр дүнтэй, ашигтайгаар хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх эрх, үүрэг бүхий 3 гишүүний бүрэлдэхүүнтэй, 2/3 буюу 2 гишүүн нь хараат бус гишүүн байна. Тус хороо нь ТУЗ-ийн бүтэц бүрэлдэхүүнд эргэн хяналт хийх, гишүүдийг сонгон шалгаруулах, үнэлэх, Гүйцэтгэх удирдлага болон удирдлагын түвшний захирлуудыг нэр дэвшүүлэх, ТУЗ-ийн үйл ажиллагааг дүгнэж тайлагнах, тэдгээрийн цалин хөлс урамшууллын хэмжээ, бодлогыг тодорхойлох, банкны бүтэц, зохион байгуулалт, засаглалыг хөгжүүлэх чиглэл өгөх зэргээр эрх үүрэгтэй хороо болно.

Эрсдэлийн удирдлагын хороо (ЭУХ)

Тус хороо нь 3 гишүүнтэй бөгөөд Банкны тухай хуулийн дагуу ТУЗ-ийн хараат бус гишүүнээр даргалуулсан, ТУЗ-ийн үйл ажиллагаанд Монгол улсын хууль журам, зохицуулагч болон олон улсын байгууллагууд, Базелийн хорооноос тогтоосон зөвлөмж, стандарт, эрсдэлийн удирдлагын тогтолцоо, бодлого зэргийн хэрэгжилтийг хянах, чиглэл өгөхөд дэмжлэг үзүүлэх чиглэлийн хороо юм. Үйл ажиллагааны өргөн цар хүрээг хамарч хараат бус байдлаар эрсдэлээс хамгаалах, зах зээл, үйл ажиллагааны эрсдэл болон комплайнсын хэрэгжилтэнд баталгаажуулалт хийж, үнэлэлт дүгнэлт, зөвлөмж өгч ажилладаг.

Аудитын хороо

Аудитын хороо нь Банкны засаглал, хууль тогтоомжийн хэрэгжилт, ёс зүйн хэм хэмжээ, санхүүгийн тайлагналт, дотоод хяналтын тогтолцоо, хөндлөнгийн болон дотоод аудитын үйл ажиллагаанд системтэйгээр дүгнэлт өгөх, банкны хувьцаа эзэмшигчид, ТУЗ болон бусад оролцогч талуудад үнэн зөв бодит мэдээллийг хүргэх замаар байгууллагын удирдлага, зохион байгуулалтын бүх түвшинд сайн засаглалын тогтолцоог бэхжүүлэх зорилготой.

Дотоод аудитын хараат бус, бие даасан байдлыг хангах үүднээс Дотоод аудитын газар нь ТУЗ-ийн шууд удирдлага дор ажилладаг ба ТУЗ-ийн дэргэдэх хараат бус гишүүнээр даргалуулсан Аудитын хороонд ажлаа тайлагнадаг нь хяналтын нэгжийн үүргийг хараат бус, бие даасан байдлаар хэрэгжүүлэх боломжийг хангадаг.

ТУЗ болон хороодуудын тайлантай танилцах:

<https://investor.tdbm.mn/memberRep/%D0%A2%D0%A3%D0%97-%D0%B8%D0%B9%D0%BD%20%D1%82%D0%B0%D0%B9%D0%BB%D0%B0%D0%BD%202023.pdf>

Засаглалтай холбоотой тайлан, мэдээ

- Нээлттэй хувьцаат компани болон хуулийн хэлбэрээ өөрчилсөнөөс хойшхи анхны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр амжилттай зохион байгуулж, дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлүүлсэн:
 - Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлт;
 - Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг батлах.
- Тайланд хугацаанд дараах тайлангуудыг гаргасан. Үүнд:
 - Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт шалгалтын журмын дагуу зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн тайлан;
 - Санхүүгийн зохицуулах хорооны Компанийн засаглалын кодекст заасны дагуу ХХБ-ны 2023 оны Засаглалын хэрэгжилтийн тайлан;
 - Байгаль орчин, нийгэм засаглалын тайлан;
 - Тогтвортой хөгжлийн тайлан;
 - 2023 оны үйл ажиллагааны тайлан;
 - 2023 оны санхүүгийн аудитлагдсан тайлан;
 - 2023 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан;
 - 2023 оны ТУЗ-ийн дэргэдэх хороодуудын ажлын тайлан;
 - ХХБ ХК-аас 2023 онд бусад оролцогч талуудтай хамтран ажилласан талаар тайлан;
 - ТУЗ-ийн хараат бус гишүүдийн хагас жил тутмын ажлын тайлан;
 - Улирал тус бүрээр Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан;
- ТУЗ-ийн дэргэд Тогтвортой хөгжлийн хороо байгуулсан;
- Тайлант хугацаанд ТУЗ 14 удаагийн хурлаар нийт 47 тогтоол гаргасан;
- ТУЗ-өөс дараах заавар журамд, нэмэлт өөрчлөлт оруулж шинэчлэн баталсан:
 - ТУЗ-ийн Үйл ажиллагааны журам;

- ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны дүрэм;
- ХХБ-ны ногдол ашгийн бодлого;
- ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны ажиллах журам.

Гүйцэтгэх удирдлага

ХХБ ХК-ийн дүрмэнд Банкны гүйцэтгэх удирдлагыг ТУЗ-өөс томилогдсон Гүйцэтгэх захирал хэрэгжүүлэхээр заасан бөгөөд ноён О.Орхон 2016 оны 1 сараас тус банкны Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. Мөн ТУЗ-ийн гишүүдээс гадна дараах албан тушаалтнуудыг Банкны эрх бүхий албан тушаалтан байхаар дүрмэнд заасан ба тайлант хугацаанд Ерөнхийлөгч болон Дижитал шилжилт хариуцсан Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогчийн гэрээний хугацаа дуусгавар болсон бол Дотоод аудитын газрын захирал урт хугацааны чөлөөнөөс эргэн томилогдсон байна.

№	Албан тушаал	Нэр	Эзэмшиж буй хувьцааны тоо, ширхэг
1	Гүйцэтгэх захирал	О.Орхон	290
2	Ерөнхийлөгч		
3	Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч	А.Энхмэнд	-
4	Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч	О.Банзрагч	-
5	Дотоод аудитын газрын захирал	Ч.Лхагвасүрэн	-
6	Санхүүгийн, удирдлага, хяналтын газрын захирал	Д.Энхтуяа	-
7	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	Н.Нямсүрэн	-

Банкны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцсэн ТУЗ-ийн дүгнэлттэй банкны цахим хуудас <https://investor.tdbm.mn/sh/SHM%2020240429.pdf> хаягт хандан танилцана уу.